

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2021. 08.01 № 1937  
танай -ны № -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан  
шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэгт тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойротг явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн иргэн Хадбаатарын Бат-Ялалт [REDACTED] ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020” Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” болон холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзнэ.

## Дүгнэлт

Иргэн Хадбаатарын Бат-Ялалт [REDACTED] ын сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-д тус тус нийцсэн байна.

Иргэн Хадбаатарын Бат-Ялалт [REDACTED] ын мөрийн хөтөлбөр /.../ хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хороонд



Д.ЗАНДАНБАТ

**УИХ-ЫН 28-Р ТОЙГИЙН НӨХӨН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
ХАДБААТАР ОВОГТОЙ БАТ-ЯЛАЛТЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2021 оны 08-р сарын 23

УЛААНБААТАР ХОТ

УИХ-ЫН 28-Р ТОЙРГИЙН НӨХӨН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ Х.БАТ-ЯЛАЛТ МИНИЙ БИЕ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙГ УДИРДЛАГА БОЛГОН МЭДЭГТҮН-70 МӨРИЙН ХӨТӨЛБӨРӨӨ ДЭВШҮҮЛЖ БАЙНА.

**Нэг.** Монгол улсад шударга ёсыг тогтоохын төлөө ажиллана. Үүний тулд шүүх, хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагаанд хараат бус хяналт тавих арга замыг судлан боловсруулж хууль санаачлах талаар идэвхтэй ажиллана.

**Хоёр.** Монгол улсад хүний эрх, эрх чөлөөг дээдлэх ойлголтыг боловсронгуй болгох тал дээр хүний эрхийн боловсрол олгох бодлого, хөтөлбөр боловсруулан ажиллана.

**Гурав.** Монголын ард түмний Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, нам эвсэл, нутаг ус, эрх мэдэл, эд хөрөнгөөр талцан хуваагддаг явдлыг таслан зогсоохыг эрмэлзэн нийгмийг эв нэгдэлд үриалах, эв нэгдлийн Үндэсний хороо байгуулах талаар санаачилга гарган ажиллана.

**Дөрөв. Хүний эрх зөрчих явдалтай тэмцэх талаар бодлого боловсруулан ажиллана.**

Тав. Төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд ард түмэн хяналт тавих арга замыг боловсронгуй болгох судалгааны ажлуудыг дэмжиж ажиллана.

**Зургаа.** Худалдаа эрхлэгчдийн эрхийг хамгаалах чиглэлээр бодлого боловсруулан хуульчлуулах чиглэлээр ажиллана.


**Долоо.** Өндөр хүүтэй санхүүгийн дарамтыг бууруулах талаар бодлого боловсруулан хууль санаачилж ажиллана.

**Найм.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, нийгмийн хэт хавтгайрсан халамжийг бууруулах талаар бодлого боловсруулан ажиллана.

Ес. Байгалийн баялаг, үүл үүрхай, хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэх чиглэлээр идэвхтэй ажиллана.

## Мөрийн хөтөлбөр боловсруулсан

Х.Бат-Ялалт



12000004